

ШИВЭЙ НАР МОНГОЛЧУУДАЙ ХОЛБОГДОХ НЬ

А. Дашдэмбэрэл

Хятадын түүхийн сурвалж бичигт IV зууны үеэс тэмдэглэгдэх болсон эртний Шивэй угсаатны хойч үр эдүгээ БНХАУ-ын ихэнх нутагт оршин амьдарч байна.

1980-аад оны дундуур гаргасан БНХАУ-ын тооллогын мэдээгээр Хятадын олон муж хотуудад нийтдээ 83629 хүн байна.¹

Ляонин, Синьцзян, Хар мөрөн, Гирин мужуудад олонх нь төвлөрөн суух боловч улсын бусад ихэнх муж хотуудад тархан суурьшжээ. Ляонин мужид 49380, Синьцзянд 27364, Хар мөрөнд 2621, Гиринд 1559, Өвөр Монголд 1471, Бээжинд 270, Шаньси-д 126, Гань-су-д 110, Шаньси-д 90, Хэбэй-д 89, Сычуань-д 83, Гуанчжоу-д 65, Хубэй-д 57, Хэнань-д 53, Хунань-д 44, Шаньдунд 41, Тяньцзинд 39, Нинся-д 29, Аньхуй-д 29, Хөхнуурт 27, Цзянсу-д 24, Гуанси-д 19, Гуань-дунд 18, Шанхайд 16, Юньнаньд 13, Цзянси-д 10, Чжэцзянд 5, Фуцзянд 3, Түвдэд 2 хүн байна.

Эдгээрийн дотроос үндэсний түүх соёл, ёс заншил, хэл бичгээ өнөө хүртэл хадгалаа үлдсэн нь СУАР-д байгаа шивэй нар юм. Шивэй нар өөрсдийгөө «Сибэ» хэмээн бичигт тэмдэглэнэ. Энэ нэр нь эртний Сяньби гэдэг нэрээс гарсан гэж үзнэ.²

Эртний хятадын түүхийн сурвалж бичгүүдэд шивэй нарыг sibe, sipi, sibi, sibi, sabi гэх мэтээр янз бүрээр тэмдэглэсэн байдаг.

Шивэй нарын гарал үүслийн талаар эрдэмтэд нэлээд судалсан боловч эдүгээ болтол нэг мөр болж чадсангүй.

МЭӨ II зууны үед Дунху-гаас Сяньби, ухуань нар салбарлаж, ухуаньнаас МЭ-ний II зууны үед ляоси, сяньби, түүнээс тоба, шивэй, кумоши нар салбарлан гарсан байна.³

Монголын нэрт эрдэмтэн Х. Пэрлээ «Хятан нар тэдний монголчуудтай холбогдох нь» бүтээлдээ Хятан, шивэй, монголын гарал үүсэл холбогдлын талаар нэлээд нарийвчлан судлахдаа «...Ляоси-сяньба-гаас хятан, шивэй нар салбарлаж, Шивэй нар нь мэнгу, шивэй, дай шивэй, мэнгу шивэйгээс мэнгу буюу монгол, дай шивэйгээс дайчууд (Тайчууд), энэ хоёроос хамаг монгол буюу да-мэнгу гарсан гэдэг санаа дэвшүүлсэн юм. Энэ нь нэн сонирхолтой бөгөөд цаашид лавшруулан судлуштай санал төдийгүй шивэй монголын гарал түүх болон харилцан холбогдлыг тогтооход үнэтэй хувь нэмэр гэж үзнэ.

Шивэй нарын олон овог аймгууд эрт дээр үеэс хамаг монголын зүүхэн талд Хянган уулын ар Нон гол, Ган мөрөн, Өргөнө гол, Буйр нуур, Хэрлэн голын адаг зэргээс удам нутгийг эзлэн байжээ.⁴

Монголын Хонгирод аймаг эрт цагт Хараун жидун (Их хянган)-аар XII—XIII зууны заагт Буйр нуур, Хүлэн нуур, Халхын голын уулзварт нутаглан сууж байсан юм.⁵ Хонгироодаас Ихэрэс, Олхунуд, Харануд, Кунгилиут хэмээх дөрвөн омог удамлан гарчээ. Энэ олхунуд аймаг нь хятадын түүхийн мэдээнд V зууны үед Улохоу гэж тэмдэглэгдсэн ба X зууны үед Кидан улсын захиргаанд орж явсан бололтой юм. Баяд аймаг ч эрт дээр үед энэ орчмоор нутаглаж байсан баргын эх удам мөн.

А. Дашдэмбэрэл — Зүүн хойг Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан.

Монгол, шивэй аймгуудын эртнээс нутаглаж байсан газар нутаг нь нэг дор хамт байгаа нь шивэй нар монгол гаралтай эртний аймгууд байж болзошгүй гэж үзэх үндэс байна.

СУАР-н шивэй нар сүүлийн үед шивэй угсаатны түүхийн судалгааны хэд хэдэн томоохон бүтээл туурвиж өөрсдийн гарал үүслийн талаар эрчимтэй судалгаа хийж байна.

1985 онд Урумчи хотноо шивэй хэлээр хэвлэн гаргасан «Сибэ үгсүрай шолокон сүдүри» бүтээлд шивэй нарын гарал үүслийн талаар эрдэмтдийн дунд 3 өөр үзэл таамаглал байна гэжээ. Үүнд:

Нэгдүгээрт, Шивэй нар бол манжтай гарал нэг болой. Энэ нь Чин улсын үед зохиогдсон «Маньчжоу юань люкай» болон Ян бинь-ий бичсэн «Лю бянь чжиляо» зэрэг зохиолуудаас үндэслэн дэвшүүлсэн санал юм. «Маньчжоу юань люкай зохиолд «Дайчин улсын Тайзүн хуандийн Нон мөрний шивэй нарт зарлиг буулгасан нь: Өчүүхэн миний бие та нарын урьдын өвөг дээдэстэй удам гарал нэг болой» гэжээ. Мөн Янь биний «Лю бянь чжиляо»-д ...Шивэй... тэдний үг хэл манжийн хамт нэг» хэмээжээ. Энэ хоёр бүлэг үгнээс л шивэй нар манжтай гарал нэг гэсэн дүгнэлтийг хийжээ. Шивэй нар эрт дээр үеэс манж нарын газар нутаг дээр аж төрж байсан хийгээд Шивэй нар манж хэл бичгийг авч хэрэглэсэн нь ч нөлөөлсөн байж болно. Нөгөө талаар Тайзүн хуандийн зарлиг буулгасан цаг үе нь манж нар шинэ тулгар улс гэрийг байгуулан зэргэлдээ олон аймаг, улсыг хүчээр буюу аргаар өөртөө татан оруулж байсан үе гэдгийг ч бодох ёстой.

Хоёрдугаарт; «Шивэй нар орчооны хамт гарал нэг болой» гэсэн таамаглал бий. Энэ нь эрдэмтдийн анхаарлыг татаагүй үлдсэн.

Гуравдугаарт: «Шивэй бол Сяньби аймгийн хойч үр мөн» Сяньби гэсэн үг аялгуу өөрчлөгдөн сибэ болсон» гэдэг таамаглалыг олон эрдэмтэд хүлээн зөвшөөрч байна.

Шивэй нарын бичсэн түүхийн бүтээлд «Шивэй нар бол Сяньбигаас салбарлан гарсан үндэстэн. Энэ бол солон ч бус монгол ч бус»⁷ гэж тайлбарласан байна.

Өнөөгийн Шивэй нарын үг хэллэгт сяньби хүний нэр цөөнгүй тохиолдоно. Сяньби нэр гэдэг хятадаар галиглан үлдсэн нэр юм. Жишээлбэл: Чүлиян, Хэлиян, сиолиян, сияндан гэх мэт Сяньби нэр байдаг бол өнөөгийн шивэй нарын дунд Юлиян, Минлиян, Фүнлиян, Жэнлиян, Пинлиян, Жүнлиян, Чинлиян⁸ зэрэг нэрүүд байгаа нь огт санамсаргүй тохиолдол бус аа.

Манай нэрт эрдэмтэн Г. Сүхбаатар⁹, Х. Пэрлээ¹⁰ нар Сяньби, Хятан нар монгол гаралтай аймаг улс болохыг түүхийн олон сурвалж, баримтаар нотлон томоохон бүтээлүүд туурвисан билээ. Гэхдээ Сяньби, Хятан нар бол монголын эртний улсууд мөн боловч эдгээрээс эрт дээр цагт ганцхан монгол бус өөр овог аймгийн олон угсаатан салбарлан гарсан байж болохыг үгүйсгэх аргагүй.

Манжийн хаад Шивэй нарыг 1699 оноос эхлэн 3 удаа нийслэл хот, Хар мөрөн муж, Или зэрэг газрууд руу нэн яаралтай нүүлгэн шилжүүлэн суурьшуулсан юм. Хаана цэргийн хүчин чадал суларч, хүч нэмэгдүүлэх шаардлагатай болсон нутгууд руу шивэй нарыг шилжүүлж хил хязгаараа бэхлэн хамгаалах арга хэмжээ авч байв. 1756—58 оны баруун монголчуудын манжийн эсрэг эрх чөлөөний тэмцэл дарагдсаны дараа хойд хил хязгаараа баттай сэргийлэн хамгаалуулах зорилгоор 1764 оноос эхлэн Шивэй нарыг Синьцзяны Илийн зүг яаравчлан нүүлгэсэн билээ. Тэр үеэс эдүгээ болтол 220 гаруй жил тэндээ суурьшиж өөрсдийн үндэсний хэл, соёл, ёс заншлаа хадгалсаар яваа билээ.

Шивэй нарыг нүүлгэн шилжүүлэх болсон гол шалтгаан бол тэдний нүүдэллэн аж төрөх эртний уламжлал, дайчин баатарлаг чадвар, моринд эрэмгий, харвах намнахад гаргуун байдал нь дайсны эсэргүүцлийг найдвартай дарж хил хязгаараа баттай хамгаалуулах зорилготой байжээ. Манжид эзлэгдсэн олон аймгуудын дотроос олон сар жилээр цаг агаарын хатуу ширүүн нөхцөлд нүүдэллэн явах тэвчээртэй нь шивэй нар байсан бололтой. Нөгөө талаар нэн эртнээс манж нартай ойр холбоотой явж тэдний хэлээр ярилцаж, үсэг бичгийг авч хэрэглэн тэдний итгэлийг бусдаас түрүүнд олж авсанд байсан бололтой. Ер нь шивэй нар бол монгол гаралтай гэж үзэж буй аймгуудын дотроос хамгийн түрүүнд манжид ууссан угсаатан гэж үзвэл зохино. Шивэй нар хорчин монголын захиргаанд, 100 илүү жил болсон учир монголчуудын дотроос хорчины ноёд манжийн төр тогтсоны дараа нэн удалгүй манжийн захиргаанд орсон билээ.

Шивэй угсаатны суурьшсан газар нутаг нь харилцан адилгүй учир авч хэрэглэсэн хэл, бичиг үсэг нь бас өөр өөр байна. Зүүн гурван мужийн Шивэй нар хятад үндэстний хамт удаан хугацаанд холилдон суусан учир хятадчилагдаж хятадаар ярьж, хятад бичиг үсгийг хэрэглэх болжээ. Өвөр Монголд суусан шивэй нар зарим нь монгол хэл бичиг, зарим нь хятад үсэг бичигт оржээ. Синьцзяны шивэй нар дээр цагаас одоо хүртэл манж хэл, бичиг үсгийг хэрэглэсээр байна. Одоогийн байдлаар дэлхийд манж хэлээр ярьж манж бичиг үсгийг гээлгүй хэрэглэн, ном хэвлэл хэвлэн гаргаж байгаа үндэстэн бол СУАР-ын шивэй нар юм.

Шивэй нарын одоогийн хэлэлцэж, хэвлэн нийтэлж байгаа хэл яриа, бичиг үсэг нь жинхэнэ манж хэл мөн үү, эсвэл шивэй нарын өөрсдийн нь үндсэн хэл үү гэдэг нь анхаарал татсан бүрэн шийдвэрлэгдээгүй асуудал юм.

Шивэй нар «...одоогийн шивэйгийн ярианы хэл бол шивэй нарын уг гарлаасаа хэлэлцэн хэрэглэсээр ирсэн өөрсдийн хэл, харин үсэг нь манж үсэг»¹¹ гэж үздэг.

Шивэй хэлээр хэвлэн гаргасан сэтгүүл, ном зохиолыг уншиж үзэхэд зарим нэгэн үгс нутгийн аялгууны хэлбэрээр дуудлага, утга нь бага зэрэг өөрчлөгдсөн боловч манж хэл мэддэг хүн уншаад ойлгохоор байдаг юм. Үүнээс үзэхэд шивэйгийн бичгийн хэл нь манж хэл мөн болно.

Шивэй нар өөрсдийн ярианы хэлээ бидний уг гарлаас хэрэглэсээр ирсэн хэл гэдгийн цаана нэгэн санаа бодол нуугдаж байх шиг. Шивэй угсаатан эрт дээр үеэс түүхэнд тэмдэглэгдсэн угсаатан байсан болохоор эртнээс авч хэрэглэсэн буюу өөрсдөө зохиосон бичиг үсэг байх ёстой. Тэр хэл, бичиг үсэг нь монгол уу манж уу гэдгийг судлан үзүүштэй одоогийн шивэй хэлэнд монгол үг маш олон бий. Шивэй хүний нэрэнд монгол буюу түвд нэрс цөөнгүй тохиолдоно.

Эдүгээ СУАР-ы шивэй нар манж хэлээр хэвлэн гаргаж буй ном бүтээлүүдэд өөрсдийнхөө угсаатны нэрийг «Сибэ үгсүра» гэж бичдэг. Дуудахдаа (siwei) гэж дуудна.

Эртний манжийн судрын хэлэнд ч одоогийн шивэй нарын хэрэглэж буй хэлэнд ч монголоор «шивэй» гэж дуудаж уншиж буй үгийг яг тэр хэвээр нь бичигт буулган бичье гэвэл эл дуудлагыг бүрэн илэрхийлэх үсгийн тэмдэгтүүд бүгд бий. Гэтэл яагаад «siwei» гэж бичихгүй «sibe» гэж бичиж байна вэ гэвэл шивэй нар эртний монгол хэлэнд өөрсдийн нэрийг тэмдэглэн нэрлэж бичиж байсан уламжлалаа хадгалах гэсэн хэрэг гэж үзэж байна. Эртний монгол хэлэнд «s»-ийн дараа «i» орвол «si» гэж дуудахгүй «si» гэж дууддаг уламжлалтай. Мөн орчин цагийн

МОНГОЛ ХЭЛНИЙ «В» (w)-гээр дуудагдах үсэг нь эртний монгол хэлэнд «б» (b)-ээр бичээд «w»-гээр дуудах болсон. Тийм учраас эртний монгол хэлэнд «sibe» гэж бичээд «siwei» гэж уншдаг. Энэ нь шувуу (sibaju), шөвөг (sibuge) гэдэгтэй адил болой. Үүнээс үзэхэд шивэй нар хэднйгээр манжбичгийг авч хэрэглэсэн ч өөрсдийн угсаатны нэрийг манжаар бус эртний монгол уламжлалаа хадгалан бичиж байгаа хэрэг болой. Иймд шивэй нар өөрсдөө эрт дээр үеэс аман ярианы хэлтэй байсан гэж үзэж байгаа болохоор тэр ярианы хэл нь эртний монгол хэлний нэгэн нутгийн аялгуу байсан болов уу гэж бодно.

1. Сибэ үгсүрай шолокон сүдүри. Өрөмч 1987, 2-р тал.
2. Мөн тэнд 18-р тал
3. Х. Пэрлээ. Хятан нар монголчуудтай холбогдсон нь; УБ. 1959. 13-р тал.
4. В. Васильев. История и древности восточной части Средней Азии СПб 1857, 32—33-р тал.
5. Д. Гонгор, Халх товчоон 1, УБ, 1970. 49-р тал
6. МНТО § 94, 176-р тал
7. «Сибэ шүвэн» 1987, № 12, 62-р тал.
8. Мөн тэнд 64-р талд
9. Г. Сүхбаатар. Сяньби, УБ. 1970.
10. Х. Пэрлээ. Хятан нар тэдний монголчуудтай холбогдох нь. УБ, 1959,
11. Сибэ үгсүрай шолокон сүдүри. Үрүмч, 1985, 452-р тал,